

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт, “Скайскрапер” ХХК-иас 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Скайскрапер” ХХК-д үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай олгосугай.

2.Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг “Скайскрапер” ХХК / Л.Бат-Эрдэнэ /-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, олон нийтэд мэдээлж ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/- т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН